



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/250-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Т.Одсүрэн Утас: 70362442 Цахим хаяг: odsurent@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5.1 Албан шаардлага	19
5.2 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ЗГ	Засгийн газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.25 № ИТ-2023/250-ИТЭТ-743
танай _____-ны № _____-т

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА, Л.ЗОРИГТБААТАР
ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 96.8 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл, урамшлын зардлыг 2.9 хувиар, НДШ-ийн зардлыг 4.1 хувиар, урсгал засварын зардлыг 15.7 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 11.0 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж нийт төсөв 3.2 хувиар хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 77.9 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд хангамж,

018020076

бараа материалын зардалд 8,318.9 мянган төгрөг, нормативт зардалд 30,240.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил үйлчилгээний төлбөр хураамжид 57,252.0 мянган төгрөг, өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид 20,167,5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	21,627,413.00	25,685,813.00
35	БАРАА МАТЕРИАЛ	21,627,413.00	25,685,813.00
35400	Хангамжийн материал	21,627,413.00	25,685,813.00
35410	Бичиг хэргийн материал	186,100.00	4,244,500.00
35420	Аж ахуйн материал	2,564,090.00	2,564,090.00
35450	Барилгын засварын материал	313,500.00	313,500.00
35470	Бусад хангамжийн материал	18,563,723.00	18,563,723.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,577,945,930.35	1,509,566,181.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,577,945,930.35	1,509,566,181.49
39200	Биет хөрөнгө	1,508,373,764.73	1,441,619,015.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,543,030,129.86	1,543,030,129.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(151,621,786.17)	(191,585,123.01)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	187,733,000.00	187,733,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(187,733,000.00)	(187,733,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	247,230,360.07	217,625,748.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(185,375,622.34)	(167,738,903.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	137,245,717.00	134,299,617.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(82,135,033.69)	(94,012,452.57)
39300	Биет бус хөрөнгө	69,572,165.62	67,947,165.58
39301	Программ хангамж	7,655,000.00	7,655,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,050,834.38)	(4,675,834.42)
39303	Бусад биет бус хөрөнгө	64,968,000.00	64,968,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,599,573,343.35	1,535,251,994.49
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,599,573,343.35	1,535,251,994.49
51	Засгийн газрын хувь оролцоо	1,599,573,343.35	1,535,251,994.49
51100	Засгийн газрын оруулсан капитал	64,968,000.00	64,968,000.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	64,968,000.00	64,968,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,534,605,343.35	1,470,283,994.49
51210	Өмнөх үеийн үр дүн	1,483,178,893.46	1,534,605,343.35
51220	Тайлант үеийн үр дүн	51,426,449.89	(64,321,348.86)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,599,573,343.35	1,535,251,994.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,080,567,162.00	1,200,496,593.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	141,875,062.00	103,092,376.96
120	Нийтлэг татварын бус орлого	141,875,062.00	103,092,376.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	95,840,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	95,840,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	141,207,060.00	3,112,376.96
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	668,002.00	4,140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	938,692,100.00	1,097,404,217.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	930,807,100.00	1,011,501,000.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	930,807,100.00	1,011,501,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,885,000.00	85,903,217.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	43,108,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,885,000.00	39,314,917.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000,000.00	3,480,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,029,140,712.11	1,264,817,942.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,029,140,712.11	1,264,817,942.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,008,731,792.99	1,208,678,604.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,856,663.50	740,669,562.25
210101	Үндсэн цалин	526,539,462.32	529,220,150.22
210102	Нэмэгдэл	114,619,961.34	122,444,044.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,990,755.80	28,155,000.00
210104	Урамшуулал	45,706,484.04	60,850,367.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,519,507.38	94,306,985.63
210201	Тэтгэврийн даатгал	69,572,672.70	65,584,036.04
210202	Тэтгэмжийн даатгал	7,554,060.19	7,730,239.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,609,807.97	5,844,831.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,299,204.77	1,377,079.88
210205	Эрүүл мэндийн даатгал	11,483,761.75	13,770,798.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,889,530.00	117,693,657.00
210301	Гэрэл, цахилгаан	3,937,111.00	7,791,914.00
210302	Түлш, халаалт	69,425,759.00	104,133,521.00
210303	Цэвэр, бохир ус	3,526,660.00	5,768,222.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,283,819.00	17,554,484.00
210401	Бичиг хэрэг	8,816,029.00	7,057,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,158,900.00	2,485,584.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,916,710.00	3,681,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,800.00	312,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,241,380.00	4,018,100.00
2105	Нормативт зардал	-	37,107,535.00
210502	Хоол, хүнс	-	37,107,535.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,519,300.00	2,893,500.00
210604	Урсгал засвар	18,519,300.00	2,893,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	4,032,000.00
210702	Дотоод албан томилолт	-	4,032,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,598,510.00	81,620,455.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	80,717,133.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,838.00	111,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,190,000.00	520,000.00
210807	Газрын төлбөр	49,897.00	56,797.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,064,463.11	112,800,425.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	34,200,000.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,064,463.11	78,600,425.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,408,919.12	56,139,338.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	21,167,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,167,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,408,919.12	34,971,838.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,408,919.12	34,971,838.12
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	51,426,449.89	(64,321,348.86)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	51,426,449.89	(64,321,348.86)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	938,692,100.00	1,193,244,217.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	95,840,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	95,840,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	95,840,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	95,840,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	938,692,100.00	1,097,404,217.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	930,807,100.00	1,011,501,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	930,807,100.00	1,011,501,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,885,000.00	85,903,217.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	43,108,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,885,000.00	39,314,917.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000,000.00	3,480,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	938,692,100.00	1,186,135,917.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	938,692,100.00	1,186,135,917.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	918,283,180.88	1,129,996,578.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,856,663.50	740,669,562.25
210101	Үндсэн цалин	526,539,462.32	526,392,650.22
210102	Нэмэгдэл	114,619,961.34	122,444,044.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,990,755.80	30,982,500.00
210104	Урамшуулал	45,706,484.04	60,850,367.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,519,507.38	94,306,985.63
210201	Тэтгэврийн даатгал	68,064,387.75	65,584,036.04
210202	Тэтгэмжийн даатгал	7,554,060.19	7,730,239.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,609,807.97	5,844,831.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,299,204.77	1,377,079.88
210205	Эрүүл мэндийн даатгал	12,992,046.70	13,770,798.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,889,530.00	117,693,657.00
210301	Гэрэл, цахилгаан	3,937,111.00	7,791,914.00
210302	Түлш, халаалт	69,425,759.00	104,133,521.00
210303	Цэвэр, бохир ус	3,526,660.00	5,768,222.00

2104	Хангамж, бараа материалын зардал	16,917,770.00	15,421,884.00
210401	Бичиг хэрэг	7,540,100.00	7,115,250.00
210402	Тээвэр, шатахуун	2,158,900.00	2,485,584.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,994,710.00	3,681,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,800.00	312,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,073,260.00	1,827,850.00
2105	Нормативт зардал	-	37,107,535.00
210502	Хоол, хүнс	-	37,107,535.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,501,200.00	3,144,500.00
210604	Урсгал засвар	18,501,200.00	3,144,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	4,032,000.00
210702	Дотоод албан томилолт	-	4,032,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,598,510.00	81,620,455.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	80,717,133.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,838.00	111,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,190,000.00	520,000.00
210807	Газрын төлбөр	49,897.00	56,797.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	36,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	36,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,408,919.12	56,139,338.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	21,167,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,167,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,408,919.12	34,971,838.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,408,919.12	34,971,838.12
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	7,108,300.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	7,108,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	7,108,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	7,108,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	7,108,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(7,108,300.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,968,000.00	1,483,178,893.46	1,548,146,893.46
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,968,000.00	1,483,178,893.46	1,548,146,893.46
9	Тайлант үеийн үр дүн	-	51,426,449.89	51,426,449.89
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,968,000.00	1,534,605,343.35	1,599,573,343.35
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	64,968,000.00	1,534,605,343.35	1,599,573,343.35
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,968,000.00	1,534,605,343.35	1,599,573,343.35
19	Тайлант үеийн үр дүн	-	(64,321,348.86)	(64,321,348.86)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	64,968,000.00	1,470,283,994.49	1,535,251,994.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,108,122,600.00	1,072,369,161.88	35,753,438.12	96.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,108,122,600.00	1,072,369,161.88	35,753,438.12	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,086,954,700.00	1,051,201,661.88	35,753,038.12	96.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	763,108,200.00	740,669,562.25	22,438,637.75	97.1
210101	Үндсэн цалин	562,653,200.00	526,392,650.22	36,260,549.78	93.6
210102	Нэмэгдэл	174,439,600.00	122,444,044.83	51,995,555.17	70.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,015,400.00	30,982,500.00	(4,967,100.00)	119.1
210104	Урамшуулал	0	60,850,367.20	(60,850,367.20)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,326,100.00	94,306,985.63	4,019,114.37	95.9
210201	Тэтгэврийн даатгал	67,019,000.00	65,584,036.04	1,434,963.96	97.9
210202	Тэтгэмжийн даатгал	7,826,800.00	7,730,239.57	96,560.43	98.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,261,400.00	5,844,831.68	416,568.32	93.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,565,400.00	1,377,079.88	188,320.12	88.0
210205	Эрүүл мэндийн даатгал	15,653,500.00	13,770,798.46	1,882,701.54	88.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,390,900.00	117,693,657.00	697,243.00	99.4
210301	Гэрэл, цахилгаан	8,347,600.00	7,791,914.00	555,686.00	93.3
210302	Түлш, халаалт	104,139,700.00	104,133,521.00	6,179.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	5,903,600.00	5,768,222.00	135,378.00	97.7
2104	Хангамж, бараа материалын зардал	8,455,000.00	8,318,900.00	136,100.00	98.4

210401	Бичиг хэрэг	2,372,600.00	2,442,250.00	(69,650.00)	102.9
210402	Тээвэр, шатахуун	703,900.00	655,600.00	48,300.00	93.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,881,700.00	3,081,200.00	(199,500.00)	106.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	582,100.00	312,000.00	270,100.00	53.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,914,700.00	1,827,850.00	86,850.00	95.5
2105	Нормативт зардал	31,104,100.00	30,240,000.00	864,100.00	97.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	170,100.00	0	170,100.00	-
210502	Хоол, хүнс	30,240,000.00	30,240,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	694,000.00	0	694,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,226,300.00	2,720,500.00	505,800.00	84.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	300	0	300.00	-
210604	Урсгал засвар	3,226,000.00	2,720,500.00	505,500.00	84.3
2107	Томилолт, зочны зардал	400	0	400.00	-
210702	Дотоод албан томилолт	400	0	400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,343,700.00	57,252,057.00	7,091,643.00	89.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,338,800.00	56,348,735.00	6,990,065.00	89.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,200.00	0	7,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	170,800.00	170,775.00	25.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,600.00	111,750.00	52,850.00	67.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	58,200.00	44,000.00	14,200.00	75.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	546,900.00	520,000.00	26,900.00	95.1
210807	Газрын төлбөр	57,200.00	56,797.00	403.00	99.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,167,900.00	21,167,500.00	400.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,167,900.00	21,167,500.00	400.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,167,500.00	20,167,500.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,400.00	1,000,000.00	400.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,108,122,600.00	1,072,369,161.88	35,753,438.12	96.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,011,501,000.00	976,529,161.88	34,971,838.12	96.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,011,501,000.00	976,529,161.88	34,971,838.12	96.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	96,621,600.00	95,840,00.00	781,600.00	99.2

350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	96,621,600.00	88,517,235.00	8,104,365.00	99.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	61	61	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	49	49	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	11	11	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	61	61	0.00	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	50	50	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,903,217.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,794,917.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,794,917.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,102,984.00
210401	Бичиг хэрэг	4,673,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,829,984.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00
2105	Нормативт зардал	6,867,535.00
210502	Хоол, хүнс	6,867,535.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	424,000.00
210604	Урсгал засвар	424,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,032,000.00
210702	Дотоод албан томилолт	4,032,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,368,398.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,368,398.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,108,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,108,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,108,300.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	85,903,217.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,903,217.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,108,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,314,917.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,480,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь цаашид (Сэлэнгэ аймгийн ХХҮГ) “Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн талаар төрөөс баримталж буй цогц бодлогыг орон нутагт чанартай, хүртээмжтэй, шуурхай, хүргэх замаар иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчинг бий болгож амжиргааны түвшинг дээшлүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх замаар нийгмийн халамж хүртээгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх.*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-д өөрчлөлт оруулсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн А/174 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,321.3 мянган төгрөгөөр буюу 4.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	21,627.4	25,685.8	4,058.4
Үндсэн хөрөнгө	1,577,945.9	1,509,566.2	(68,379.7)
Нийт хөрөнгө	1,599,573.3	1,535,252.0	(64,321.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,599,573.3	1,535,252.0	(64,321.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,599,573.3	1,535,252.0	(64,321.3)

Бараа материалын дансны үлдэгдэл 25,685.8 мянган төгрөг болж 4,058.4 мянган төгрөгөөр өссөн нь ХЭДС-аас Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд зохион байгуулах сургалтад ашиглагдах “Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн эмхэтгэл 4,140.0 мянган төгрөгийн үнэтэй 360 ширхэг номыг үнэ төлбөргүй хүлээн авснаас голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,155,311.5 мянган төгрөг болж 32,550.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 7,108.3 мянган

төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, ХХҮЕГ-аас 4,231.2 мянган төгрөгийн киоск-төхөөрөмж, скайнерыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан болон ТӨБЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 697 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 90 дугаар тогтоолоор 43,890.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,535,252.0 мянган төгрөг болж 64,321.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг улсын төсвөөс 1,157,578.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 28,663.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3,957.1 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 51,739.7 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 1,699.9 мянган төгрөгөөр,
- эд хогшил, урсгал засварын зардлыг 6,388.7 мянган төгрөгөөр,
- Томилт, зочны зардлыг 1,923.3 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 71.5 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 3,730.2 мянган төгрөгөөр зэрэг нийт дүнгээр **40,847.4** мянган төгрөгөөр бууруулж, **1,116.730.9** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт зохицуулалт хийж 8,608.3 мянган төгрөгөөр бууруулан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 491.7 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 13,197.0 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 945.8 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 115.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 19,566.6 мянган төгрөгөөр,

- Норматив зардлыг 1,469.4 мянган төгрөгөөр,
- Томилолт, зочны зардлыг 117.9 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 2,203.9 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Ингэснээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,011,501.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 96,621.6 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,011,501.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 95,840.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,072,369.1 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 35,753.4 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>						
д/д	Хөтөлбөр,	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71902-Нийгмийн халамж	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	888,234.1	873,809.5	14,424.6	98.4
		80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	97,236.8	88,517.2	8,719.6	91.0
		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	21,167.9	21,167.5	0.4	100.0
2	72102-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	102,099.0	88,874.9	13,224.1	87.0
Дүн			1,108,122.6	1,072,369.1	35,753.4	96.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ХХҮЕГ-аас өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа, амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс, хяналт шинжилгээ үнэлгээний дотоод албан томилолт, улсын мэдээллийн маягтын зардлыг санхүүжүүлэхэд 40,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас 2 арга хэмжээнд 50,108.3 мянган төгрөг, Мобиком ХХК-иас байрны түрээсийн төлбөрийн 4,350.0 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 70.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар комиссоос 3,092.4 мянган төгрөг зэрэг 97,620.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, 85,903.2 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн ашиглалтын хугацаа дуусаж элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн цаашид дахин ашиглах боломжтой хөрөнгүүдийн ашиглалтын жилийг шинэчлэн тогтоох, албан хаагчдад олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлсэн, үнэлгээтэй уялдуулан олгож байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,029,140.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,291,4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, ажлын хүрээнд ХХҮЕГ-ын 2022 оны 01/1613 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

Дэд даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, орон тоог хязгаарлах замаар цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 26,457.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 697.2 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардлыг 136.1 мянган төгрөг, нормативт зардлыг 864.1 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 505.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил үйлчилгээний зардлыг 7,091.6 мянган төгрөг, бусад зардлыг 0.8 мянган төгрөг зэрэг нийт **35,753.4** мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 125 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 24 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт / 3, 5, 7 сар, 1 дүгээр улирлын мэдээлэл /,
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /3, 7 дугаар саруудад/,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /3, 7 дугаар саруудад/,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл / 3, 5, 7 дугаар саруудад/,
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл /3, 7 дугаар саруудад/,
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг /3, 7 дугаар саруудад /,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл /7 дугаар сард/,
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр /3, 5, 7 дугаар саруудад/,

- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт /7 дугаар сард/
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /3, 5, 7 дугаар саруудад/
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн / 7 дугаар сард/

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, дүгнэсэн боловч урамшууллын хувь хэмжээг ажлын гүйцэтгэлтэй уялдуулалгүйгээр буюу 85.0-95.0 хувьтай үнэлэгдсэн бүх албан хаагчдад нэгэн адил 40.0 хувиар олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулан үндсэн цалингийн 40.0 хүртэлх хувиар ялгаатай олгож байх, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтэй зарцуулж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, албан хаагчдын улирлын ажлын мөнгөн урамшууллыг ажлын үнэлгээтэй уялдуулалгүйгээр олгосон байгаа нь Төсвийн тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 4,129.3 мянган төгрөгийн зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт
----------	------------------------	---------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	4,129.3	-	-	-
Нийт дүн	1	4,129.3	-	-	-

Өмнөх онд өгөгдсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Мобикомд жил бүр байр түрээслүүлж тодорхой хэмжээний түрээсийн орлого / 2022 онд **3,480.0** мянган төгрөг /-ыг тогтмол төвлөрүүлдэг боловч уг орлогыг төсвийн орлогын төлөвлөгөөнд тусгалгүйгээр нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн, зарцуулж байна.
- Тус газрын үйл ажиллагааны ахлах нягтлан бодогч Б.Идэрчулуун, халамжийн сан хариуцсан мэргэжилтэн Г.Дорждэрэм нарын ажлыг улирал бүр дүгнэж, ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 40.0 хувиар тооцож олгосон боловч ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/315 дугаар тушаалаар салбарын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1,651.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно, 15.1.3: Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар ХХҮЕГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн 2,480.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд ангилал буруу бүртгэсэн алдааг залруулав.

Аудитаар нийт 7,149.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 6,367.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага

1. Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 781.6 мянган төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Туслах үйл ажиллагааны орлогыг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж байх, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 6,367.5 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 41 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн ангилал буруу илэрхийлсэн	1	2,480.0			1	2,480.0	1	2,480.0				
Дүн	1	2,480.0			1	2,480.0	1	2,480.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг дутуу төвлөрүүлсэн.	1	781.60			1	781.60						
Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тайлант онд давтан гаргасан.	1	6,367.50			1	6,367.50						
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, 0 үлдэгдэлтэй боловч ашиглагдаж байгаа 41 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй.	1	-					1					
Дүн	3	7,149.1			2	7,149.1	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	24						24	
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	24						24	
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Албан хаагчдын улирлын ажлын мөнгөн урамшууллыг ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулалгүйгээр нэгэн адил 40 хувиар хавтгайруулан олгосон.	1						1	
Дүн	1						1	
Нийт дүн	25						25	